



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 02 сарын 07 өдөр

Дугаар 45

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн
өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүдийг
томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 2.10 дахь заалтыг тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын 2018 оны 05/753 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлт, Эрчим хүчний сайдын 2017 оны а/4220, Өмнөговь аймгийн Засаг даргын 2017 оны 1-2665 дугаар албан бичгээр ирүүлсэн саналыг харгалзан төрийн өмчит зарим хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүдийг хавсралтад заасан ёсоор 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА


Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦӨТГЭЧ

Э.ЭРДЭНЭХИШИГ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн
45.. дугаар тогтоолын хаворалт



ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨвлӨЛД ТӨРИЙН ӨМЧИЙН
ТӨЛӨӨЛӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТОМИЛОГДОХ
ГИШҮҮДИЙН НЭРС

Д/д	Хуулийн этгээдийн нэрс	Төрийн эзэмшилийн хувь	Томилогдох гишүүд
1	“Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК	100	Ц.Бурмаа (Өмнөговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга)
2	“Хөвсгөл дулааны станц” ТӨХК	100	Л.Нямдорж (Эрчим хүчний яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)
3	“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК	100	Э.Ишбаяр (Өмнөговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны дарга)